


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 06 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-24 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 8 аймагт **1324** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1324 тохиолдлын 94% /1246/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /78/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /9/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **367** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **24** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.06.08 – 06.14)

2025 оны эпидемиологийн 24 дугаар долоо хоногт угаарын хийн хордлого бүртгэгдээгүй байна. Өмнөх оны мөн үеэс 0 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 2 дахин тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-24 дугаар долоо хоногт нийт 621** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


365Эмнэлгийн
тусламж авч буцсан**256**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
45%Эмэгтэй
55%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 24 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **20** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурсан, сүүлийн 5 жилийн дунджаас 42 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 24 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	2	4	6
2	Эмийн хордлого	4	10	14
Нийт		6	14	20

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санамсаргүйгээр** өртсөн тохиолдлууд зонхилж байгаа бөгөөд шалтгаанаар нь авч үзвэл бага насны хүүхэд асран хамгаалагчын хяналтгүйгээр эм, эмийн бүтээгдэхүүн хэрэглэж хордсон байна. **Санаатайгаар** өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 17-32 насны хүмүүс байгаа бөгөөд олон тооны эм хольж уусан байна.

-оОо-